

**Р.ОЮУНБАДАМ***Шихихутуг Хууль зүйн дээд сургуулийн багш,**Хууль зүйн ухааны доктор (Ph.D)*

ЭМЭГТЭЙЧҮҮДЭД ХОРИХ ЯЛ ЭДЛҮҮЛЭХ БОДИТ ШААРДЛАГА, УЧИР ШАЛТГААН

Монгол улс дахь эмэгтэйчүүдийн хорих ял: Онол, арга зүйн, практик сэдэвт диссертацийн бүтээлээс үндэслэж эрдэм шинжилгээний хуралд онэхүү сэдвээр илтгэл бичсэн болно.

Эмэгтэй хүнд хорих ял оногдуулах эдлүүлэх талаар зөвхөн эмэгтэйчүүдийг дангаар нь аваад тусгайлан судлах хууль, эрх зүйн орчин өнөөгийн байдлаар Монгол улс төдийгүй олон улсын хэмжээнд бүрдээгүй болно. Хорих ялын асуудлыг судлаачид ихэнхдээ тухайн ялын үндэслэл, нөхцлийг эрүүгийн эрх зүйн талаас нь голчлон судалж ирсэн боловч хорих ял эдүүлэх эрх зүйн зохицуулалт талаас төдийлөн судлаагүй ялангуяа эмэгтэй ялтны ял эдлүүлэх үйл ажиллагаа харьцангуй бага судлагдсан байдаг.

Зарим талаараа огт судлагдаагүй ч гэж хэлж болно. Энэ байдал ганц Монгол Улсын хэмжээнд ч биш дэлхийн улсуудад ч мөн адил байдаг нь яагаад гэвэл Дэлхий дээр хорих ял эдэлж байгаа 19 хүний 1 нь эмэгтэй (5,2%) байдаг тул шоронгийн зохион байгуулалт ихэнхдээ эрэгтэй хүнд зориулагдсан байдагтай холбоотой гэж үзжээ. Нөгөөтэйгүүр олон улсын хэмжээгээр баримталдаг нэг зарчим бол эмэгтэй гэмт хэрэгтэнд хорих ял эдлүүлэх нь тун нарийн төвөгтэй асуудал бөгөөд нэг эмэгтэйн асуудал 20 эрэгтэй хүний асуудалтай адил гэж үздэг.

Монгол улсын нийт ялтны дотор эмэгтэй ялтан /50 жилээр/ 1963-2012 оноор судлан үзэхэд 360918 ялтнаас 24983 нь эмэгтэй (6,9%) эзэлж байна. Үүнийг дэлхийн 159 улс орнуудтай харьцуулан үзэхэд Монгол улс 65-рт байгаа судалгаа бий. Тухайлбал эмэгтэй ялтны эзлэх хувийн жин Тайланд улсад 20%, Болив улсад 16,7%, Парагвай 11,3%, Коста Рика улсад 10,8% гэх мэт орнуудад эмэгтэйчүүд гэмт хэрэг үйлдэх нь бусад орнуудаас

ондөр хувьтай болох нь харагдаж байна.

Зүүн Өмнөд Азийн нэгэн жижиг улс Брунэ Дарамсалад ганцхан эмэгтэй хорих ял эдлэж байгаа бол эмэгтэй хоригдол байхгүй улс орон ч олон байна.

Эрдэмтдийн өгсөн томъёоллоор хорих ял нь хамгийн хатуу ял учраас бусад төрлийн ялаар ялын зорилгод хүрч чадахгүй гэж үзжээ. Тийм нөхцөлд л хорих ялыг биечлэн эдлүүлдэх учиртай. 1963 оныг 2012 онтой харьцуулан үзвэл Монгол улсын хэмжээгээр ял шийдгүүлсэн бүх хүн 2,9 дахин өссөн бол үүнээс ял шийтгүүлсэн шийтгүүлсэн бүх эмэгтэй 4,4 дахин өссөн байна.

Монгол улс эмэгтэй хүнд хорих ял эдлүүлэх үйл ажиллагаа зөвхөн өнөө үеийн асуудал биш өнө эртний Хүннү гүрнээс эхлэлтэй, олон мянган жилийн баялаг түүхтэй орон юм. Хүннү гүрнээс Эрүүгийн төрөлжисөн хууль хүртэл төрөлжсөн хуулиас өнөөг хүртэл хэрэгжиж ирсэн 90 жилийн түүхэн уламжлалыг судлан үзэхэд хууль цаазын ялгамж холбоо тасраагүй явсаар өнөөтэй золгосон байдаг. Энэ бүхнээс дараах дүгнэлтэнд хүрсэн юм. Гэмт хэрэг үйлдэж, гэм буруу нь шүүхээр тогтоогдсон нөхцөлд хүйсийн (эрэгтэй, эмэгтэй) ялгаваргүйгээр ял оногдуулж ирсэн байдаг. Харин хорих ял эдлүүлэхдээ эмэгтэй хүн, насанд хүрээгүйчүүдэд бусдаас хөнгөн байдлаар ял эдлүүлэх хуулийн зохицуулалттай байна.

Эмэгтэй хүн өнө эртнээс гэмт үйлдэл, гэмт хэрэг үйлдсэний улмаас шийтгүүлж байсан тухай товч авч үзье:

МЭӨ 4 дүгээр зууны үед оршин тогтнож байсан Хүннү, Сүмбэ, Нирун, Монгол угсааны бус Түрэг, Уйгар, Кидан улсууд оршин тогтнож байсан үед гэмт хэрэг үйлдэж ялт унасан хүнийг зөвхөн гар урлалын ажилд зүтгүүлдэг байсан нь Монгол улсад эрүүгийн ял шийдтгэл эдлүүлэх эрх зүйн эх сурвалжийг Хүннү улсын хууль цаазаар эхлэл тавьсан гэж үзэх бүрэн үндэстэй байна. XII зууныг хүртэлх үед Монгол аймгуудын дотор ялтан буюу баригдагсдыг айл хэсгүүлэн хорих арга хэрэглэж байсан. Энэ нь гэмт хэрэг хийсэн хүнийг нэг талаар хорьж, нөгөө талаар олон нийтэд жигшүүлж байсны илрэл гэж үзэж болохоор байна. Эмэгтэй хүнд холбогдолтой зарим зохицуулалтаас үзвэл Аймгийн тэргүүлэгчдийн эхнэр энгийн харц ардтай ханилан явалдсаныг мэдэгдсэн даруй хөвчдөж алж, явалдсан эрийн эцэг эх хөвгүүн ах дүүсээс нэг л хүнийг үлдээж бусдыг цөм үхэх ялд унагааж, охид, гэр тэрэг бүх малыг хурааж авдаг талаар дурджээ.

Дүгнэвэл: Монголд олон овог аймаг оршин тогтнож байх үед эмэгтэй хүнд холбогдуулсан садар самуун явалд үйлдэх, гэр бүлийн ариун ёс заншлыг зөрчих, эр нөхрөө үл хүндэтгэх зэргийг гэмт хэрэгт тооцож байсан бөгөөд хөвчдөн алах, ураг төрлийн хүмүүсийг нь алах, малыг хураах, торгох ял оногдуулдаг байсан гэж үзэж болохоор байна.

Чингис хаан хулгай, худал, дээрэм, тонуул, дэг журамгүй үйлдэл бүрийг хайр найргүй устгаж тэмцэхийг чухалчилдаг байсны дотор эмэгтэй хүний тухай зарим зохицуулалтыг дурьдвал: Эмэгтэй хүн шалиглан

явалдах, хүү нь эцэгтээ, эхнэр нь нөхөртөө захирагддаггүй замбараагүй үйлдлийг гэмт хэрэгт тооцдог байсан. Эм хүн бол газар сайгүй түмэнд зэрэг харагдаж байдаг наран бус орон гэрээ цэвэр цэмцгэр авч явах үүрэгтэй, журамтай байх нь эр нөхөрийн нэр хүндийг өргөж байх учиртайг, мөн цэрэг дайныг эмэгтэйчүүд дагалдан явахыг, эр нөхөр нь дайнаас буусан үед ч эр нөхөрийнхөө ажил үүргийг орлон гүйцэтгэж байхыг тус тус зарлиглаж байжээ.¹³ Энэ зарлигаараа Чингис хаан нь Эмэгтэй хүнийг эр хүний нэгэн адил чадалтай гэж үзэж, эр хүний ажлыг хийхнийг даалгаж байсан гэж үзэх бүрэн үндэслэлтэй байна. Их Засаг хэмээх Монгол төрийн нэгдсэн хууль: Эмэгтэй хүн гэмт хэрэг үйлдсэн гэж үзэх тодорхой үйлдлийг гэр бүл салах, хулгай хийх, хүүхэд эцэг эхдээ, эхнэр нөхөртөө захирагдах ёсыг зөрчих, дайнд явсан эр нөхөрийн ажил үүргийг муу орлон гүйцэтгэсэн байх, охид буруугаар ураглах зэрэг шинж байдлаар тодорхойлж, тийм үйлдлийг гэмт хэрэгт тооцож алах, цөлөх, занчих, ойр төрлийн хэн нэгнийг нь алах зэрэг ял оногдуулдаг байсан байна. Монгол Улсын Эрүүгийн хуулийн анхны эх үүсвэрүүдийн нэгэн томоохон төлөөлөл монголын нэгдсэн төрийн болж хууль цаазын нэг нь Түмдийн Алтан хааны цааз бичгийг өмнөх эх сурвалжуудтай харьцуулан судлах явцад:

“Өсгөж хүмүүжүүлсэн хүүхдээ алсан хүн, хэрэв төрүүлсэн эцэг эх нь байсан бол тэднийг алах түүний ойр төрлийн аль нэг хүнээр ор босгох, занчих, тэргүүн ёсоор торгох ял шийтгэлийн аль нэгийг ногдуулах тухай заасан. Гэмт үйлдлийн хувьд ийм агуулга бүхий заалт 1934 оны Хууль цаазын бичигт тусгалаа олж байсан ба 2002 оны Эрүүгийн хуулийн 92 дугаар зүйлд Эх нь нярай хүүхдээ төрөх явцад буюу төрмөгц алсан бол 5 жил хүртэлх хугацаагаар хорих ял шийтгэхээр хуульчилсан нь тухайн гэмт үйлдлийн хувьд энэ үйлдэлийг анхнаасаа нийгэмд аюултай гэж үзжээ. Монголын хууль цаазын уламжлалд халх журам хууль: онцгой байр суурь эзэлж байдаг. Халх журам хууль 13-20 зууны эхэн үе хүртэл үндсэндээ 220н жил үйлчилж иржээ. Энэ хуулийн эмэгтэй хүнд хамаатай байх гэмт үйлдлийн тухай заалтуудаас авч үзвэл ноёдын хураасан аргал түлээ болон шанаг,зүү,тэвэн,сам,шүүр цайны идээ хулгай хийсэн үйлдэлийн гэмт үйлдэлт тооцож ял шийтгэл оногдуулдаг байжээ.

1913 оноос эхэлж боловсруулсан зарлигаар тогтоосон хууль зүйлийн бичгийг боловсруулж баталжээ. Энэ хууль 65 дэвтэрээс бүтсэн байдаг. Энэ хуулийн 49 дүгээр дэвтэрт эмэгтэй хүн, хүнийг алсан бол шоронд хорино гэж тусгайлан заажээ. 1921 онд хаант төрийн шоронгоос хэрэгтэнүүдийн суллан тавихад нэгэн хошуунд нэг эмэгтэй хүн хоригдож байв гэж тэмдэглэсэн байдаг.

Хорих ял эдлүүлэх нь эмэгтэй хүнд төдийгүй бүх хүнд маш хүндээр тусдаг хатуу ял юм.

Хорих ял түүний хатуу нь юу юм бэ гэдэг талаар Монголын эрдэмтэдийн

зарим үзэл баримтлалыг тоймлон авч үзвэл:

Доктор Г. Совд: Хорих ял нь манай эрүүгийн эрхээр тогтоосон ял шийтгэлүүдийн дотор нилээд хүнд нь учраас түүнийг нийгмийн хор аюулаар их гэмт хэрэг үйлдсэн этгээдэд буюу хувийн чанараараа нийгмээс тусгаарлагдах шаардлагатай этгээдэд оногдуулдаг ял юм. Хорих ял бол юуны урьд тодорхой хугацаатай ял шийтгэл мөн хэмээн тодорхойлсон байна.

Доктор, Профессор А.Лхагва, С.Жанцан: Хорих ялын зорилго бол ял эдлэгчдийг цээрлүүлэхийн зэрэгцээ тэднийг засан хүмүүжүүлэх явдал юм.

Хорих ялын зорилго, агуулгын талаар манай улсын эрдэмтэн, судлаачдын дунд зарим талаар онолын үзэл баримтлалын хувьд санал зөрөлдөх явдал гардаг боловч сүүлийн үед энэ хандлага багасч, үндсэндээ нэгдмэл байр суурьтай байна.

Академич С. Нарангэрэл: “Хорих ял бол Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан үндсэн бөгөөд хамгийн хатуу төрлийн ял мөн. Хорих ялын үндсэн агуулга нь ялтныг олон нийтээс тусгаарлаж харуул, хамгаалалт, хяналт бүхий хорих тусгай байгууллагад байлгахад оршино. Энэ ял нь гол төлөв онц хүнд, хүнд гэмт хэрэг үйлдэгсэд, онц аюултай гэмт хэрэгтэнд зориулагдсан ял юм. Ялын зорилго гэмт халдлагаас иргэн нийгмийг хамгаалах, энэ нь хохирогчийн хуулиар хамгаалагдсан эрх ашгийг юуны өмнө хамгаалах утга агуулгатай гэжээ.

Судлаач Т.Дэндэв: Хорих ялын тухай асуудал нь ял шийтгэлийн нэлээд өргөн ойлголт юм. Энэ нь БНМАУ-ын 1961 он Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 17, 19 дүгээр зүйл тусгай ангийн 45-63 дугаар зүйл ангиудад бүрэн тусгалаа олсон. Хорих ялыг аль болохоор богино хугацаанд хэрэглэж байвал илүү үр дүнтэй байх талтай учир нь гэмт хэрэг үйлдсэн этгээдэд заавал хорих ял хэрэглэж нийгмээс тусгаарлахгүйгээр хорихоос өөр төрлийн ял өгч болох юм. Хорих ялыг тусгай зохион байгуулалагдсан байгууллагад эдлүүлнэ.

ОХУ-ын судлаач профессор А.С Михлин: үзэхдээ “... Хорих ялын зорилго нь тухайн ялтан этгээдийг залхаан цээрлүүлэхээсээ илүү гэмт зан төлөвийг нь засан төлөвшүүлэх буюу нийгэмшүүлэхэд чиглэгддэг учраас зарим онцлог статус бүхий хорих ял шийтгүүлсэн ялтны (хүүхэд, эмэгтэйчүүд) тухайн ялыг эдлүүлэх дэглэмийн нөхцөл, эрхийн хязгаарлалтыг шинээр авч үзэх шаардлагатай байна гэж үзжээ.

ОХУ-ын Профессор Б.С Волков: эрүүгийн хариуцлагыг “Хувь хүнд нийгэм, төр, хамт олны гишүүн болохын хувьд тавьж буй хуульд заасан шаардлагыг зөрчсөн тохиолдолд сангийн хэлбэртэй эрх зүйн тодорхой үр дагавар бий болох явдал” гэж оновчтой тодорхойлжээ.

Эдгээр эрдэмтэд өөр өөрийн гэсэн өвөрмөгц ялгаатай онолын томъёолол хийсэн ч эцсийн эцэст дараах томъёолалууд дээр нэгдмэл байна.

• Хорих ял бол бүх төрлийн ял эрүүгийн хариуцлагын дотороос

хамгийн хатуу ял мөн.

- Тэднийг гэмт хэрэг хийснийх нь төлөө эрх, эрх чөлөөг нь хуульд зааснаар хязгаарлаж харуул хамгаалалттай тусгай төрөн байгууллагад аваачиж байлгана.

- Ялын зорилго нь иргэд, нийгмийг, хохирогчийг хамгаалах агуулагатай гэх зэрэг болно.

Харин манай эрдэмтэн А.Лхагва: Ялтныг цээрлүүлэхийн зэрэгцээ тэднийг хүмүүжүүлэх зорилготой гэжээ. Хорих ял нь хамгийн хатуу ял учраас бусад төрлийн ялаар ялын зорилгод хүрч чадахгүй. Ийм нөхцөлд хорих ялыг биечлэн эдлүүлэх учиртай.

Ялын агуулгын талаар Академич С.Нарангэрэл хийсэн, бас шинэ томъёолол нь. Тэгэхдээ тусгаарлалтыг “нийгмээс тусгаарлана” гэж үзвэл эзгүй газарт гав ганцааранг нь байлгахаас өөр аргагүйд хүргэх болно.

Хорих ял эдэлж буй этгээд эргэлт, уулзалт авна. Захидал харилцаагаар харилцана. Телевиз, сонин, сэтгүүл, ном зохиолуншина. Гэр бүлийнхэнтэйгээ ойр дотны хүмүүстэй уулзана. Өмгөөлөгчөөс мэргэжлийн туслалцаа авч болно. Нүглээ наманчилж ламаар ном уншуулах шүтэж бишрэх эрх нь хасагдахгүй. Шаардлагатай үед хорих газрын эмнэлэгээс гадуур энгийн эмнэлэгт эмчлүүлж болно. Ингээд үзэхээр тэднийг нийгмээс бүр мөсөн тусгаарлагдсан гэж үзэж болохооргүй байна.

Иймд тусгаарлалтыг нийгмээс бус олон нийтээс тусгаарлаж байна гэж үзсэн байна.

... Судлаач эрдмийн зэрэг горилохдоо: Өнөөгийн болон Академичийн хийсэн онолын томъёолол нь орчин үед эргэлзээ төрүүлэх боллоо гэсэн дүгнэлт хийсэн юм.

Онолоос үзсэн ч практикт ажиллаж байхад ч: Ер нь хорих ялын хамгийн хэцүү нь нэг талаар ялтны амьдралын хамаг хэмнэл нь цагин хатуу хувиараар, хатуу дэглэмээр явагдах нь ихээхэн хэмжээний зүдгүүр, шаналгааг буй болгодогт оршино. Нөгөө талаар ялангуяа жирийн дэглэмд хорих эдлэж байгаа засрал хүмүүжил сайтай зарим эмэгтэй ялтныг олон нийтээс тусгаарлаж байна гэж үзэхэд эргэлзээтэй болж байна гэж үзсэн. Учир нь: хүнд гэмт хэрэг үйлдсэн эмэгтэйчүүд жирийн дэглэмд ял эдлэж эрх зүйн байдлын олон зүйл хязгаарлалгүй болсон.

Тэд хуульд заасан үндэслэлээр чөлөө авч гэр бүл болон олон нийтийн дунд тодорхой хугацаагаар амьдардаг.

- Сургалт хүмүүжлийн ажилд хорих байгууллагын ажилтнуудаас гадна шашны, буяны болон бусад байгууллага иргэдийг оролцуулж болно гэж хуульчилсан тул олон нийттэй харьцаж байна.

- Жирийн дэглэмд ял эдэлж буй хоригдлыг харуул хамгаалттайгаар аж ахуй нэгж байгууллагад гэрээгээр ажиллуулж болно гэсэн хуулийн дагуу эмэгтэй ялтнууд 1997-2007 он хүртэл “Буян” ХХК-д, 2012 оноос “Урбаник”

ХХК-д ажиллаж тухайн компаний ажилчдын дунд өдрийн 8 цагаар хөдөлмөрлөсөн практик юм Энэ бүхэн хорих ял эдэлж буй эмэгтэйчүүд, ялынхаа тодорхой хугацааг олон нийтийн дунд өнгөрүүлж байгааг харуулж байна.

Сэтгэц, гэм судлаач Ч.Ломброзо: эмэгтэй хүн өс санадаг, бас хэрцгий, нэг хийснээ дуусгадаг гэсэн онолын томъёолол хийсэн нь бий. Энэ нь парактикт зарим талаараа бодитой байх тала ажиглагддаг юм. Ч.Ломброзогийн үндэслэлийг цааш нь хөгжүүлсэн (1895) Фереро, Клэйн (1923) Томас (1966) Кононка нар тус тус гэмт хэрэгтэн эмэгтэйчүүдийн биологийн болон сэтгэл зүйг эрэгтэй хүнийхээс өөрөөр авч үзэх ёстойг онолын хүрээнд дэвшүүлэн тавьжээ. Гэсэн ч эдгээр сэтгэгчид бусад урсгалуудын эсэргүүцэлтэй тулгарч байжээ.

Хэдийгээр эмэгтэй хүнд хорих ял ногдуулах нэг ёсны бодит шалтгаан байгаа боловч эрэгтэйчүүдийн гэмт явдалтай харьцуулахад өвөрмөц ялгаа бий.

Тухайлбал:

- ☐ Нийт гэмт хэргийн дотор эмэгтэйчүүдийн үйлдсэн гэмт хэрэг их биш байдаг.
 - ☐ Эмэгтэйчүүдийн нийгэмд гүйцэтгэх үүрэг роль, ихэнх эмэгтэйчүүд хүч чадал сэтгэхүй нь эрэгтэйчүүдтэй хаьцуулахад их бус юм.
 - ☐ Бүлэг гэмт явдалт эмэгтэйчүүд гол төлөв хоёрдугаар зэргийн үүрэг гүйцэтгэдэг.
 - ☐ Зохион байгуулагч ба гүйцэтгэгчийн чиг үүрэг гүйцэтгэх нь маш цөөн тохиолдолд гарна.
 - ☐ Эмэгтэйчүүд хүч хэрэглэн гэмт хэрэг үйлдсэн нь их цөөн байдаг.
 - ☐ Монгол улсад эмэгтэйчүүдийн үйлдсэн хүний амины санаатай зарим гэмт хэргийг судалж үзэхэд хохирогчийн буруутай ажиллагаа зохих хэмжээгээр нөлөөлсөн нөхцөл байдал илрэн гардаг.
 - ☐ Ялангуяа хохирогчийн зүгээс хүч хэрэглэсэн, дарамталсан, сэтгэл санааны хүнд байдалд оруулсан байдал ажиглагддаг.
 - ☐ Эмэгтэйчүүдийн гэмт явдлын дотор шунахай сэдэлттэй гэмт хэрэг гол байрыг эзэлж байна.
 - ☐ Тэгэхдээ өмчийн эсрэг гэмт хэрэг голлож байгаа нь судалгаагаар ажиглагдсан.
 - ☐ Эмэгтэйчүүдийн шунахай гэмт явдлын бүтэц эрэгтэйчүүдийнхээс зарчмын ялгаатай байдаг. Энэхүү ялгаа нь эмэгтэйчүүдийн үйлдсэн шунахай төрлийн гэмт хэргийн шинжээр тодорхойлогдоно. Үүнийг дараах судалгаануудаас харж болно.
- Ялын бодлогыг түүхэнд тодорхойлж ирсэн онолын 4 урсгал байдаг.
- ☐ Авсальот онол
 - ☐ Харьцангуй онол

☐ Таслан зогсоох онол

☐ Либериаал онол

Судлаач: эмэгтэйчүүдэд хорих ял эдлүүлэх онцлогийг гүнзгийрүүлэн судлахад харьцангуй онолын төвшинд судлах нь илүү үр дүнтэй гэж үзсэнийг тэмдэглэх зүйтэй юм.

Харьцангуй онол: ялтныг залхаан цээрлүүлэхдээ гол нь биш, эргээд нийгэмшүүлэхэд чиглэгдсэн онол юм.

Эмэгтэйчүүдэд хорих ял эдлүүлэх нь яагаад бодит шалтгаан болоод байгаа юм бэ? гэдгийг дараах цөөн судалгаанаас харъя.

Хорих ял эдэлж буй эмэгтэйчүүдийн дунд урьд нь хорих ял эдэлж байсан эмэгтэйчүүдийн хувийн жин өндөр байна. Сүүлийн 14 жилийн дунджаар судлахад хорих ял эдэлж буй эмэгтэйчүүдийн 3-ан хүний нэг нь урьд нь хорих ял эдэлж байжээ.

ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ДЭГЛЭМИЙН БАЙДАЛД ХИЙСЭН СУДАЛГААНААС

д/д	Он дараалал	Нийт хоригдлын тоо	Чанга дэглэмтэй эмэгтэй	Эзлэх хувь
1.	2000	170	8	4.7
2.	2001	250	16	6.4
3.	2002	369	19	5.1
4.	2003	242	28	11.5
5.	2004	261	35	13.4
6.	2005	311	41	13.2
7.	2006	223	53	23.7
8.	2007	308	55	17.8
9.	2008	368	53	14.4
10.	2009	323	55	17.0
11.	2010	362	66	18.0
12.	2011	396	70	17.6
13.	2012	404	71	17.5
14.	2013	358	76	21.2

Зарим эмэгтэйчүүд өөрийн буруу зан төлөвшилийн доголдол, гэмт зан үйлийн улмаас гэх мэтээр олон учир шалтгаанаар гэмт хэрэг үйлдэж нийгэм иргэдэд хор уршиг учруулан ял шийтгүүлэх түүний дундаас хорих ялаар шийтгүүлж байгаа нь жилээс жилд өссөөр иржээ. Гэвч гэмт хэргийн нийгмийн шинжтэй шалтгаан ялангуяа эрүүгийн бодлого эмэгтэй хүнд бусад шийтгүүлэгчдийн нэгэн адил нөлөөлж байна.

ШҮҮХЭЭС ХОРИХ ЯЛЫГ ИЛҮҮТЭЙ ХЭРЭГЛЭХ БОЛСОН НЬ ЭМЭГТЭЙ ХҮНД НОГДУУЛЖ БҮЙ ХОРИХ ЯЛ НӨЛӨӨЛЖ БАЙГАА НЬ

1963-1982 оны судалгааны дотроос хэсэгчилэн харьцуулан үзэхэд 20 жилд нийтдээ 6895 эмэгтэй ял шийтгүүлж байжээ. 1984-1986 онд хоёрхон жилийн дотор 1942 эмэгтэй хорих ял шийтгүүлсэн байна. Үүнийг 1963-1972 он хүртлэх 10 жилтэй харьцуулан үзвэл 1900 эмэгтэй хорих ялаар шийтгүүлж байв. Өмнө дурдсанаас дүгнэхэд Эрүүгийн хуульд аливаа хүний үйлдсэн гэмт хэргийн нийгмийн хор аюулд тохирсон ялыг буй болгох, шүүх ялыг шударга ногдуулах зэрэг нь эмэгтэйчүүдэд хорих ялыг биечлэн эдлүүлэх явдлыг одоогийнхоос хавьгүй илүүгээр бууруулах нөхцлийг бүрдүүлэх болно гэж үзэв.

1961 оны Эрүүгийн хуулийг зарим эрдэмтэд үзэхдээ их хатуу хууль учир нь зарим талаараа хүний амь нас эрүүл мэндээс социалист өмч дээгүүр тавигдсан байв гэжээ. Судалгааны явцад олдсон нэгэн сонирхолтой жишээ бол: Нэгдэлийн хонины нүд сохолсон хэрэгтэй (малтай зүй бусаар харицсан) нэг эмэгтэй хорих ял эдлэж байсан байдаг юм.

2003-2012 он хүртлэх сүүлийн 10 жилд 7705 эмэгтэй шүүхээр ял шийтгүүлсэн байна. Ийнхүү сүүлийн 10 жилд ял шийтгүүлсэн эмэгтэйчүүдийн тоо 1963-1982 он хүртлэх 20 жилд ял шийтгүүлсэн эмэгтэйчүүдийн тооноос давж байгааг юу харуулж байна вэ? гэвэл 2002 оны Эрүүгийн хуулийг хэт хатууруулсан, санкцыг шүүхээс сонголт хийх боломжгүй болгосонд оршино. Өөр нэг нөлөөллийг авч үзье. 1993.6.7-ны өдрийн эрүүгийн хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтөөр зарим төрлийн онц хүнд гэмт хэрэгт онцгой тохиолдолд хорих ялын дээд хугацааг 25 жил, ердийн дээд хэмжээ 10 жил байсныг 15 жил болгосон явдал эмэгтэйчүүдийн хувьд хүндээр тусч тэднийг удаан хугацаагаар шоронд суулгаж шороншуулах байдалд хүргэжээ. Хорих ялын хугацааг эрүүгийн хуулиар уртасгасан байдлыг дараах судалгаанаас харж болно.

1983 онд тэр үеийн МАХН-ын Төв хорооноос хууль сахиулах байгууллагад гарч байсан алдаа завхралын талаар 316 дугаар тогтоол гаргаж, ял тэнсэх, хуульд зааснаас хөнгөн ял оногдуулах журмыг шүүхээс хэрэглэх асуудалд хөндлөнгөөс оролцож, эдгээр институтыг хэрэглэхгүй байх чиглэлийг өгч байжээ. Үүнээс болж ямар статистикс харагдаж байв.

Ийнхүү эмэгтэйчүүд онц хүнд, хүнд гэмт хэргийг ихэвчлэн үйлдэж 50 гаруй хувь нь 5-25% жилийн ял эдэлж байгаагаас тэдэнд маш олон сөрөг үр дагавар үүсдэг.

Эмэгтэй ялтан ял эдэлж байх үеийн хүнд, хэцүү нөхцөл байдлын дээр

эмэгтэй хүний хүйсийн байдлаас хамаарч бусдаас илүүтэй хүндрэл бэрхшээлийг даван туулдаг. Тэгвэл энэ бэрхшээлтэй байдлыг бие даан даван туулж, суллагдсны дараа хэвийн амьдралд буцаж орох нь тэр бүр хүнд тохиолдохгүй тэвчээр хатуужлийг шаардах нь дамжиггүй. Хорих газраас суллагдсны дараа үүсэх эрх зүйн үр дагавар нь Монгол улсын эрүүгийн хуулийн 78 дугаар зүйлд заасан ялтанд тооцогдох хугацаа үйлчлэх явдал юм. /Ялтай байдал/ нь эрх зүйн нилээд үр дагаврыг буй болгож байна.

Эдгээрээс цөөнийг дурьдвал: ял шийтгэлтэй хугацаа дуусаагүй байхад зарим албан тушаалыг эрхлэх эрхгүй байна. Зарим төрлийн тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхлэх тухайлбал өмгөөлөл, нотариат, хувийн хамгаалалтын зэрэг үйл ажиллагаа явуулах эрх нь хасагдсан гэх мэт.

Эрүүгийн хуульд ял шийтгэлтэйд тооцох хугацаа тогтоосны гол учир холбогдол нь ялтай хугацаа өнгөрөөгүй байхад шинээр гэмт хэрэг үйлдвэл ялыг шүүх хүндрүүлэхэд оршино. Гэтэл энэ хугацааг нь ял шийтгүүлсэн хүнийг ажил амьдралгүй болгох, ирээдүйдээ итгэлгүй болгоход элдэв төрлийн дотоод журам заавар нөлөөлж байна.

Хорих ял эдэлж байгаа нийт эмэгтэйчүүдийн 68,7% нь ар гэрийнхний байдал, үр хүүхэддээ санаа зовдог гэнэ. Эмэгтэйчүүдийн дийлэнх хувь нь 74,8% нь өрх толгойлсон, 80 гаруй хувь нь бага насны хүүхэдтэй бөгөөд тэдгээр хүүхдүүдэд хадамдаа, өөрийн эцэг эхдээ, ах дүү садандаа үлдээдэг. Хүүхэд асран хамгаалах газруудад эх нь ял эдэлж буй 20 гаран хүүхэд асруулан хүмүүжиж байна. Тандалт судалгаагаанд хамрагдсан эмэгтэйчүүд давхардсан тоогоор 49% нь тэднээс найз нөхөд нь нүүр буруулсан, 42,6% нь ах дүү хамаатан садан хүмүүс нь нүүр буруулсан, 36,1% нь орон гэрээ алдсан, 35,3% нь гэр бүл салсан, 27,7% нь хүүхэд нь сургуулиас завсардсан болон эд хөрөнгөө алдсан, 23,5% нь гэр бүлийн хэн нэгэн нь нас барсан, 16,8% нь хүүхэд гэр оронгүй тэнэмэл амьдралтай болсон гэж хариулжээ. Энэ бүхэн хорих ял эдэлж байгаа эмэгтэйчүүдээс хамаатан садны хүмүүс нь нүүр буруулж, эд хөрөнгө орон гэрээ алдах, хүүхэд нь сургуулиас завсардах, тэнэмэл болох, гэр бүлийн гишүүдийн хэн нэгэн нь нас барах, нөхөр нь салах зэрэг хар бараан үр дагавар дагуулж эцэг эх, үр хүүхэд нь хорих ялын цээрлэлийг давхар амсдаг гэсэн дүгнэлтэнд хүрч байна. Нөгөө талаар хорих ял эдэлснээр бусдад учруулсан (гэм хорын) төрбөр төлөгдөх боломжийг ямар нэг хэмжээгээр хаадаг муу нөлөөтэй юм.

Эдгээр үр дагавараас хамгийн ноцтой үр дагавар нь эмэгтэйчүүдийн цөөнгүй нь нөхөн үржихүйн идэвхтэй насаа хрих ял эдлэж өнөрүүлж байгаагаас насаараа хүүхэдгүй эмэгтэй болж байгаа нь нууц биш юм.

Дүгнэлт

□ Гэмт хэрэг үйлдэж гэм буруу нь тогтоогдсон этгээдэд шүүхээс хүйсийн ялгаваргүйгээр ял оногдуулж иржээ. Хууль шүүхийн өмнө хүн бүр тэгш эрхтэй болохоор хүйсийн ялгамжгүйгээр оногдуулах гарцаагүй биз ээ.

- Эмэгтэйчүүд хүнд ноцтой гэмт хэрэг илүүтэй үйлдэж байгаа нь хорих ялыг шүүхээс биечлэн эдлүүлэхээс өөр аргагүйд хүрч байна.
- Эмэгтэйчүүдийн 90 шахам хувь нь онц хүнд, хүнд гэмт хэрэг үйлдэж байгаа учраас үүнтэй холбоотойгоор хорих ялын хугацаа урт байна. Иймд хорих ялын хугацааг багасгах шаардлагатай байна.
- “Эмэгтэйчүүдэд ял оногдуулах, тэрдундаа хорих ял оногдуулах нь өнө эртнээс өнөөг хүртэл эрх зүйн бүхэл бүтэн бие даасан тогтолцоо болтлоо хөгжиж ирсэн институт юм”.
- Ийм учраас ялангуяа хорих ял эдэлж буй эмэгтэйчүүдийн ялыг эдлүүлэх нөхцөл журам, тэднийг нийгэмшүүлэх асуудлыг байнга судлан, шинэчилж, улмаар эрүүгийн хууль тогтоомжийг төгөлдөржүүлэх нь хууль зүй судлалын судалгааны нэн чухал объект мөн.
- Эрх зүйн шинэчлэлийн хүрээнд 2002 оны Эрүүгийн хуулийг зайлшгүй өөрчлөхөд хүргэж байна.
- Шинээр боловсруулж УИХ-д хэлэлцэх гэж буй гэмт хэргийн тухай хууль, ял эдлүүлэх нийгэмшүүлэх тухай тэдгээрт нийцүүлэн гарах дүрэм журмыг батлуулах шаардлагатай байна.